



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Өндөрхаан

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 15 цаг 10 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан өрөөнд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн Ж.Гантулга, Г.Лхагвахатан, Л.Бат-Октябрь, Д.Эрдэнэбаатар, Б.Баярсайхан, Г.Болд, С.Бат-Эрдэнэ, Ж.Болд, нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар удирдан эхлүүлэв.

Хэлэлцсэн асуудал:

1. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт, комисс томилох, төлөвлөгөө гаргах
2. Б.Түмэнжаргалын өргөдлийг шийдвэрлэсэн дүгнэлтийг танилцуулах
3. Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай
Э.Мягмарсүрэнг Бэрх хотын ЗАА-ны дотоод ажил, мэдээлэл сурталчилгаа хариуцсан түшмэлээр, Д.Баттулгыг АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнээр
4. Т.Энхнаран нөөцөд бүртгүүлэх /Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх түүгээр үйлчлэх журмын 4.2-т 23.3.1-р ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц/
С.Алтанцэцэг нөөцөд бүртгүүлэх /Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх түүгээр үйлчлэх журмын 4.2-т 23.3.1-р ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц/
5. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Баянмөнх сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны сул орон тоо зарлах тухай
Байгаль орчин аялал жуулчлалын газар Ойн албаны даргын аулын байр, Баянхутаг, Биндэр, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Батноров, сумдад Байгаль хамгаалагчийн ажлын байрны сул орон тоо зарлах тухай
Хэрлэн сумын 1,5-р багийн зохион байгуулагчийн сул орон тоо
ГХБХБГ-ын Хэрлэн, Баян-Адрага, Баян-Овоо, Галшар, Мөрөн, Цэнхэрмандал, Хурх ХБУ газрын даамлын сул орон тоо нөөцөөс бүртгэлтэй иргэдээс нөхөх, ажлын байрны сонгон шалгаруулалт зарлах тухай

СОНССОН НЬ 1:

Гишүүн Б.Баярсайхан: Б.Түмэнжаргалын өргөдлийг хянан шалгасан дүгнэлтийг уншиж танилцуулав. Маргаан хянан шалгах комиссын даргаар Б.Баярсайхан, гишүүдээр Б.Сүнгээ, Ц.Ганчимэг нар ажилласан.

Дүгнэлтээр Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/63 дугаартай "Б.Түмэнжаргалд сахилгын шийтгэл ногдуулах тухай" тушаал хууль бус байна.

Салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар: асуулт байна уу саналаа хэлээрэй

Гишүүн Ж.Гантулга: Дүгнэлтийг сонслоо. Урьдчилж мэдэгдээгүй. 1995 оны 97 дугаар тогтоолоор Захиргааны ерөнхий хуульд заасан 40 дүгээр заалттай холбоотой заалтууд ерөнхийдөө зөрчигдсэн тушаалыг өмнөх хурал дээр харсан энэн дээр ямар нэгэн нотлох баримт байхгүй сонсох ажиллагаа хийгдээгүй учраас Баярсайхан даргаар ахлуулсан ажлын хэсгийн дүгнэлттэй санал нэг байна. дэмжиж байна.

Салбар зөвлөлийн дарга Ж.Ганбаатар: Бусад гишүүд

Гишүүд: Санал нэг байна.

Б.Баярсайхан: Тогтоол дүгнэлт 2-ыг тухайн байгууллагад хүргүүлээд биелэлтийг харах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар Боловсрол,соёл, урлагийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/63 дугаартай "Б.Түмэнжаргалд сахилгын шийтгэл ногдуулах тухай" тушаал хууль бус байна гэж үзлээ. Тогтоол гарган тогтоол дүгнэлтийг тухайн байгууллагад хүргүүлэх. Тогтоол дээр Хууль эрх зүйн хэлтсийн дарга болон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга нар хяналт тавин ажиллана. Тогтоолын төсөл цуг орж ирсэн бол дараа дараагийн хурал дээр маргаан шийдвэрлэж байгаа бол тогтоолын төсөлийг оруулж байх.

СОНССОН НЬ 2:

Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа: Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Баян-Адрага, Мөрөн, ХБУ тосгоны Соёлын төвийн захирал нарын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт зарлагдаж байгаа. Тухайн ажлын байрны зарыг Төрийн албаны зөвлөлийн сайт болон Хэнтий. мн сайтууд болон орон нутгийн ТВ-үүдээр дээр зар хүргэгдэж байгаа. 22 нд бүртгээд 24-нд шалгалт авна. Шалгалт авах комисс томилох

Дарга Ж.Ганбаатар: Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулах журмыг нарийвчлан заагаад өгсөн. Энэ тогтоол зааснаар сонгон шалгаруулах комиссыг салбар зөвлөл болон боловсролын газрын шийдвэрээр 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулах ёстой. Шаардлагатай бол төрийн бусад байгууллага, тухайн салбарын мэдлэг туршлагатай албан тушаалтанг оролцуулж болно гэсэн байгаа. Комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилох уу?

Комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн даргыг ямар бүрэлдэхүүнтэй байвал зүйгээр вэ? Байх ёстой бүрэлдэхүүнд мэргэжлийн байгууллагын хүн байх нь. Миний хувьд яг энэ салбарын манай зөвлөлийн гишүүн Г.Лхагвахатан даргаар ахлуулаад нарийн бичгийн даргаар төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Болормаа, гишүүдэд соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнгөнзул, Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга Болд, Мэргэжлийн хяналтын газрын Соёлын байцаагч Отгонцолмон нарыг оролцуулах саналтай байна. Өөр гишүүдэд санал байна уу?

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Гишүүдийн 100 хувийн саналаар комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Сонгон шалгаруулалтын явцад Төрийн албаны зөвлөлөөс ирсэн чиглэл, аргачлалыг маш сайн мөрдлөг болгон ажиллах

СОНССОН НЬ 3:

Ч.Болормаа: Энхбаатарын Мягмарсүрэнг Бэрх хотын ЗАА-ны дотоод ажил, мэдээлэл сурталчилгаа хариуцсан түшмэлээр нөөцөөс нэр дэвшүүлэх тухай албан бичиг ирсний дагуу судалж үзэхэд Э.Мягмарсүрэн нь Баянхутаг сумын ЗДТГ-ын даргын ТЗ-7-оор 2017 оны 4 дүгээр 02 дугаар сарын 14-нд шалгалт өгч тэнцэн, 2017 оны 02 дугаар сарын 20-ны 15-р тогтоолоор нөөцөд бүртгэгдсэн.

Ж.Ганбаатаяр: Бэрх хотынх манайхаар ажлын байраа зарлуулсан уу. Зарлуулахгүйгээр шууд нөхөж байна уу? Үүн дээр ямар саналтай байна?

Г.Болд: ТЗ-7 д шалгалт одоо ТЗ-3-д ажиллах юм байна. Ажлын байрны тодорхойлолт нь хамгийн гол нь таарч байна уу. Ажлын байрны тодорхойлолт таарч байвал нөөцөөс нэр дэвшүүлэхийг дэмжиж байна.

Ганбаатар: өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй бол нөөцөөс нөхөх үү

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Бэрх хотын ЗАА-ны даргын хүсэлтийн дагуу Энхбаатарын Мягмарсүрэнг нөөцөөс нэр дэвшүүлэх тогтоол гаргах. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах

СОНССОН НЬ 4:

Ж.Ганбаатар: Т.Энхнаран, С.Алтанцэцэг нарыг нөөцөд бүртгүүлэх хүсэлт гаргасан: Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэн түүгээр үйлчлэх журмын 4.2-т 23.3.1-р ажлаас чөлөөлөгдсөн

3//.

албан хаагчийн нөөц, Энэ эсуудал нь заавал хурлаар оруулахгүй журмаар шийдэгдэх асуудал. Иймд салбар зөвлөлийн тайланд мэдээг нь оруулаад явуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Журмаа үндэслэн бүртгэж авах
Өмнөх хурлаар оруулсан сул орон тоон дээр нэмээд нийт дэс түшмэлийн 13, туслах түшмэлийн 23 орон тоог нөөцөөс нөхөхөөр зарлах. Журмын дагуу албан бичиг явуулах.
Хурлын үйл ажиллагааг 17:10 минутад дуусгав.

ХУРАЛ УДИРДСАН:

Ж.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН:

Ч.БОЛОРМАА

